

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Танилцуулгад улсын төсвийн 34 ерөнхийлөн захирагчийн 1646 төсөвт байгууллага, нийслэл, дүүргүүд болон 21 аймгийн 5058 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан болон Нийгмийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно. Түүнчлэн төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын гүйцэтгэл 7.3 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 591.1 тэрбум төгрөгөөр давж, нэгдсэн төсвийн зарлага 9.0 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 477.1 тэрбум төгрөгөөр дутуу гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцэл 1 их наяд 742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, Дотоодын нийт бүтээгдэхүүн¹ - ий 6.4 хувьтай тэнцэж байна.

Улсын төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын 2017 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 5.2 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 446.4 тэрбум төгрөгөөр буюу 9.4 хувиар давж, улсын төсвийн зарлага 7.1 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 281.0 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар бага байна.

Тогтворжуулалтын сан

Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2017 оны турш тэнцвэржүүлсэн үнээс дээгүүр байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд 325.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

¹ ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 27,167.0347 сая төгрөг
Эх сурвалж САНГИЙН ЯАМ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗАР, МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2017 онд 7,274.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 8.8 хувь буюу 591.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Харин 2017 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,439.9 тэрбум төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2017		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,259,541.1	7,958,264.6	698,723.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	242,417.9	325,680.2	83,262.4
ИРЭЭДҮЙН ӨВ САН	333,345.1	357,722.8	24,377.6
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,683,778.2	7,274,861.6	591,083.5
1.Татварын орлого	5,717,767.4	6,315,131.9	597,364.4
Орлогын албан татвар	1,354,833.5	1,613,192.8	258,359.3
Хувь хүний орлогын албан татвар	670,198.0	695,076.1	24,878.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,355.2	-44,474.2	-119.0
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ х	316.0	446.0	130.0
ААН-ын орлогын албан татвар	728,674.7	962,144.9	233,470.2
Нийгмийн даатгалын орлого	1,242,340.3	1,321,375.2	79,034.9
Хөрөнгийн албан татвар	112,608.3	131,129.6	18,521.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,448,504.9	1,618,492.1	169,987.2
Онцгой албан татвар	511,577.7	519,721.5	8,143.8
Тусгай зориулалтын орлого	11,941.1	12,386.6	445.5
Гадаад үйл ажиллагааны орлого	489,784.0	512,351.2	22,567.2
Бусад татвар, төлбөр, хураамж	546,177.6	586,482.8	40,305.2
2.Татварын бус орлого	966,010.7	959,729.8	-6,280.9
Нийтлэг татварын бус орлого	888,236.7	896,708.4	8,471.7
Хөрөнгийн орлого	1,197.1	1,187.9	-9.2
Тусламжийн орлого	76,576.9	61,833.5	-14,743.4

Сая төгрөг

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 6,315.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 597.4 тэрбум төгрөгөөр илүү буюу 10.4 хувиар давсан байна.

Татварын орлогын төрлүүдээс орлогын албан татвар 258.4 тэрбум, нийгмийн даатгалын орлого 79.0 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 170.0 тэрбум, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 40.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан нь нийт татварын орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлжээ.

Харин татварын бус орлогын гүйцэтгэл 959.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 6.3 тэрбум төгрөгөөр тасарч, 99.3 хувийн биелэлттэй байна. Хүү, торгуулийн орлого 15.9 тэрбум, газрын тосны орлого 6.2 тэрбум, навигацийн орлого 2.7 тэрбум, бусад орлого 26.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн ч, хувьцааны ногдол

ашиг 7.6 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 34.9 тэрбум, гадаадын хандив тусламжийн орлого 14.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс тасарсан нь нийт татварын бус орлого дутуу биелэхэд голлон нөлөөлжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 110.4 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 102.6 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 103.7 хувь байна.

1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2017 онд 9,017.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 5.0 хувь буюу 477.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн зарлага

ҮЗҮҮЛЭЛТ	2017		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,494,421.8	9,017,318.6	-477,103.2
А. УРСГАЛ ЗАРДАЛ	7,235,657.4	7,043,161.7	-192,495.7
1. Бараа, ажил үйлчилгээний зардал	3,269,497.8	3,141,432.3	-128,065.5
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,815,359.5	1,800,434.6	-14,924.9
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	234,162.9	229,747.4	-4,415.6
3. Хангамж, бараа материалын зардал	125,587.2	123,540.1	-2,047.1
4. Нормативт зардал	252,643.2	250,218.9	-2,424.3
5. Эд хогшил, урсгал засварын зардал	58,565.1	58,148.0	-417.1
6. Томилот, зочны зардал	22,640.8	21,415.4	-1,225.4
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,066.7	352,668.1	-52,398.6
8. Бараа үйлчилгээний бусад зардал	355,472.2	305,259.9	-50,212.3
2. Хүү	1,156,688.1	1,156,465.1	-223.0
3.Татаас	289,103.4	207,346.1	-28,484.2
4. Урсгал шилжүүлэг	2,520,368.1	2,537,918.1	-35,723.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,904,940.2	1,658,140.7	-246,799.5
1. Барилга байгууламж	1,260,902.6	1,121,662.4	-139,240.2
2. Их засвар	76,563.2	66,992.7	-9,570.5
3. Тоног төхөөрөмж	118,536.5	86,836.1	-31,700.4
4. Бусад хөрөнгө	412,626.8	351,331.0	-61,295.8
5. Стратегийн нөөц хөрөнгө	36,311.2	31,318.6	-4,992.6
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	353,824.2	316,016.2	-37,807.9
1. Эргэж төлөгдөх зээл	180,295.2	200,817.3	20,522.1
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	173,529.0	115,198.9	-58,330.1

Сая төгрөг

Бараа, үйлчилгээний зардал 128.1 тэрбум, хөрөнгийн зардал 246.8 тэрбум, цэвэр зээлийн зардалд 37.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Тайлант 2017 онд улсын төсвийн зарлага 7,420.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөснөөс 7,139.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 96.2 хувийн буюу 281.0 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл

	2016 оны		2017 оны	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	9,495,332.9	9,494,421.8	9,017,318.6	-477,103.2
Улсын төсөв	7,394,235.5	7,420,601.4	7,139,637.5	-280,963.9
Орон нутгийн төсөв	2,330,426.6	2,623,517.7	2,437,066.4	-186,451.4
Нийгмийн даатгалын сангийн төсөв	1,720,277.5	1,907,540.6	1,890,850.6	-16,690.0

Сая төгрөг

Орон нутгийн төсвийн зарлага 2,437.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 7.1 хувь буюу 186.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 195.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 1,890.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 16.7 тэрбум төгрөгийг дутуу зарцуулсан байна.

1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл 1,745.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 4. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл

	2016 оны		2017 оны	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	-3,660,289.1	-2,810,643.6	-1,745,249.9	1,065,393.7
Улсын төсөв	-3,499,792.1	-2,693,312.8	-1,965,954.9	727,357.9
Орон нутгийн төсөв	-160,630.1	-247,985.4	110.5	248,095.9
Нийгмийн даатгалын сангийн төсөв	89,634.7	130,654.6	220,594.5	89,939.9

Сая төгрөг

Улсын төсвийн тэнцэл 1,966.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, орон нутгийн төсвийн тэнцэл 110.5 сая, НДС-ийн төсвийн тэнцэл 220.6 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд 3,126.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг дотоодын зах зээл дээрх ЗГҮЦ-ны арилжаанаас бүрдүүлсэн ба тус эх үүсвэрээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 5,431.8² тэрбум төгрөг, үүнээс тусгай зориулалтын үнэт цаас буюу Сайн малчин, Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үнэт цаасны үндсэн төлбөрт 1,078.0 тэрбум төгрөг, улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 3,673.9 тэрбум төгрөг, Хүний хөгжил сангийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт

² Үүнээс векселийн дүн 307.2 тэрбум төгрөг

372.7 тэрбум төгрөг, векселийн үндсэн төлбөрт 307.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

Олон улсын зах зээл дээрх ЗГҮЦ-ны арилжаанаас 3,463.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн байна. Мөн 751.5 тэрбум төгрөгийн гадаадын төслийн зээл, 1,478.1 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг авч ашигласан байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр

	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	НДС-ийн төсөв
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,745,249.9	-1,965,954.9	110.5	220,594.5
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,745,249.9	1,965,954.9	-110.5	-220,594.5
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,010,429.3	-755,899.2	-33,935.6	-220,594.5
ЗГ-ын бонд	206,613.0	206,613.0	0.0	0.0
Урт хугацаат	206,925.8	206,925.8	0.0	0.0
Дотоод	-2,305,397.6	-2,305,397.6	0.0	0.0
Шинээр гаргах	1,759,934.2	1,759,934.2	0.0	0.0
Үндсэн төлбөр	-3,065,331.8	-3,065,331.8	0.0	0.0
Худалдаж авах	-1,000,000.0	-1,000,000.0	0.0	0.0
Гадаад	2,512,323.4	2,512,323.4	0.0	0.0
Шинээр гаргах	3,463,141.0	3,463,141.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-950,817.6	-950,817.6	0.0	0.0
Богино хугацаат	-312.8	-312.8	0.0	0.0
Дотоод	-312.8	-312.8	0.0	0.0
Шинээр гаргах	1,366,168.8	1,366,168.8	0.0	0.0
Үндсэн төлбөр	-1,366,481.5	-1,366,481.5	0.0	0.0
ЗГ-ын зээл	1,794,729.6	1,766,054.7	28,674.9	0.0
Дотоод	-269,616.6	-269,616.6	0.0	0.0
Авлага	196,855.0	196,855.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	196,855.0	196,855.0	0.0	0.0
Төсвөөс эргэн төлөгдөх	-466,471.6	-466,471.6	0.0	0.0
Төлөх	-466,471.6	-466,471.6	0.0	0.0
Гадаад	2,064,346.2	2,035,671.4	28,674.9	0.0
Төслийн зээл	586,241.6	557,566.7	28,674.9	0.0
Шинээр авах	751,487.3	722,812.4	28,674.9	0.0
Үндсэн төлбөр	-165,245.7	-165,245.7	0.0	0.0
Хөтөлбөрийн зээл	1,478,104.7	1,478,104.7	0.0	0.0
Дэлхийн банк	297,824.7	297,824.7	0.0	0.0
Шинээр авах	297,824.7	297,824.7	0.0	0.0
Азийн хөгжлийн банк	491,320.0	491,320.0	0.0	0.0
Шинээр авах	491,320.0	491,320.0	0.0	0.0
Япон	688,960.0	688,960.0	0.0	0.0
Шинээр авах	688,960.0	688,960.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	160,000.0	160,000.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	572,106.5	572,106.5	0.0	0.0
Өмч хувьчлал	22,230.0	17,079.8	5,150.2	0.0

Сая төгрөг

1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн орлогын тусгай шаардлага: Монгол Улсын 2017 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2017 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2017 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 4,599.4 ам.доллар байхаар тооцож, зэсийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд 242.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 6. 2017 оны Зэсийн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс, ам.доллар	5,149.8	6,162.3	-1,012.5

Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2017 оны турш тэнцвэржүүлсэн үнээс буюу 4,599.4 ам.доллараас дээш байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд орлого 325.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн тэнцлийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна..” гэж тусгасан.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

		2017 он
1	Хуулиар тогтоосон хязгаар	-10.4%
2	Гүйцэтгэл	-6.4%

2017 оны төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл - 1,741.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -6.4 хувьтай тэнцэж байгаа нь тус шаардлагыг хангаж байна.

Зарлагын өсөлтийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

Хүснэгт 8. Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

		2017 он
1	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	-5.4%
2	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	9.0%
3	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	21.8%

Өрийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т төсөвт баримтлах өрийн тусгай шаардлагыг тодорхойлсон. Улмаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг 2017 оны төсвийн жилд 85.0 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан.

Хүснэгт 9. Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд

		Тэрбум төгрөг
ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2017.12.31
I. Засгийн газрын дотоод өр		4,230.1
1.1	Үнэт цаас	3,461.9
1.2	Өрийн бичиг/вексель	0.0
1.3	Концесс	768.2
II. Засгийн газрын гадаад өр		16,857.8
2.1	Үнэт цаас	7,701.6
2.2	Зээл	9,156.2
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг		1,663.7
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	1,663.7
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		22,751.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		20,211.4
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		85.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		74.4%

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2017 оны эцэст 22,751.6 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 20,211.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 74.4 хувьтай тэнцүү байгаа нь өрийн тухай тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар ногдуулахаар тус тус заасан бөгөөд одоогийн байдлаар 250 гаруй төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2017 оны гүйцэтгэлээр 699.8 тэрбум төгрөг³ буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 9.6 хувьд хүрсэн байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт 10. Татварын зарлагын хэмжээ

Байгууллага	2017 он	Бүтэц хувиар
Татварын байгууллага	525.51	75.10%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	273.22	39.00%
Хувь хүний орлогын албан татвар	125.54	17.90%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	126.76	18.10%
Гаалийн байгууллага	174.37	24.90%
Гаалийн албан татвар	54.97	7.90%
Онцгой албан татвар	12.25	1.70%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	107.16	15.30%
Нийт татварын зарлага	699.88	100.00%

Тэрбум төгрөг

³ Татварын зарлагын дүнд НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь хэсэгт заасан экспортын уул уурхайн бүтээгдэхүүний албан татварын чөлөөлөлт хамрагдаагүй болно. Энэхүү зохицуулалт нь татварын орлогыг нэмэгдүүлэх зохицуулалт тул татварын зарлага хэсэгт хамруулаагүй болно. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар гадаад улсын засгийн газартай байгуулсан давхар татварын гэрээний дагуу үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг энэ тооцоонд оруулсан болно.

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 75.1 хувь буюу 525.5 тэрбум төгрөгийг татварын алба, 24.9 хувь буюу 174.4 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

Өнгөрсөн 2017 онд татварын зарлагыг бууруулах хэд хэдэн арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлсэн. УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Онцгой албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, эдгээр хуульд тусгасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулсан. Тухайлбал:

- хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулах онцгой албан татварын хөнгөлөлтийг бууруулсан;
- арилжааны банканд байрших хадгаламжийн хүүгийн орлогыг татвараас чөлөөлдөг байсныг зогсоосон болно.

1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2017 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 1,230.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс 61 хувь буюу 753.2 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 9.0 хувь буюу 105.7 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 6.0 хувь буюу 74.5 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын арга, 12.0 хувь буюу 148.8 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах арга, 5.0 хувь буюу 65.8 тэрбум төгрөгийн шууд худалдан авалтаар, 2.4 тэрбум төгрөгийн олон нийтийн оролцооны аргаар, 7.0 хувь буюу 80.2 тэрбум төгрөгийн зөвлөх үйлчилгээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт 8341 тендер шалгаруулалт зарласан байх бөгөөд үүнээс 1769 нээлттэй тендер шалгаруулалт, 2777 харьцуулалт, 738 шууд гэрээ байгуулах, 74 хязгаарлагдмал тендер шалгаруулалт, 2399 шууд худалдан авалт, 193 олон нийтийн оролцоо, 391 зөвлөх үйлчилгээний аргаар тус тус тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.7-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын ирүүлсэн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, тендерийн урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3

дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Батлан хамгаалахын сайд, Говь-Алтай, Дорноговь, Орхон, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга нар 90-96.9 хувь буюу “Маш сайн”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Ховд аймгуудын Засаг дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрчим хүчний сайд, Эрүүл мэндийн сайд, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Завхан, Өвөрхангай, Нийслэл, Төв аймгийн Засаг дарга нар, Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Үндэсний статистикийн хорооны дарга 60-79 хувь буюу “Хангалттай”, Зам тээврийн сайд болон Улсын ерөнхий прокурор 40-59 хувь буюу “Хангалтгүй”, Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга 0-39 хувь буюу “Муу” үнэлгээ тус тус авсан байна.

Тайлан ирүүлээгүй 3 төсвийн ерөнхийлөн захирагч байсан бөгөөд 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хөрөнгө оруулалтын зардлын төсөв батлагдаагүй тул үнэлгээнд хамруулаагүй болно.

Улсын хэмжээнд 2017 оны худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт нийт 72 хувь буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ авч байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногийн дотор хянан хариу өгөх үүрэгтэй байдаг. 2017 онд нийт 813 гомдол хүлээн авч хянан үзсэн байх бөгөөд түүний 453 гомдол нь захиалагчийн шийдвэр хуульд нийцээгүй, 222 гомдол нь захиалагчийн шийдвэр хуульд нийцсэн гэж шийдвэрлэгдсэн байна. Үүнээс дүгнэж үзвэл нийт хянан үзсэн гомдлын 55.3 орчим хувь буюу дийлэнх нь захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 101 дугаар зүйл болон Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын 2-т заасан дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах заалтын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн тайлангаас үзэхэд 2017 онд нийт 22 төсвийн ерөнхийлөн захирагч дотоодод үйлдвэрлэсэн нийт 12 нэр төрлийн бараанаас 47.1 тэрбум /дөчин долоон тэрбум нэг зуун гучин гурван сая/ төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах нийтлэг зөрчил, дутагдлууд гарчээ. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны цахим /www.tender.gov.mn/ нэгдсэн системийг нэвтрүүлэн худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зарлах тухай Засгийн газрын 2017 оны 17 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт хангалтгүй байна.
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд 2017 онд нийт 4595 тендерийн урилга, 3104 тендер шалгаруулалтын үр дүн нийтлэгдсэн байна. Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд зарлан мэдээлэх чиглэлээр хангалтгүй ажилласан;
- Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх нь хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд захиалагч тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль болон холбогдох журмыг зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа зөрчил гарсан хэвээр байна.
- Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа хэт өндөр шалгуур тавьж өгснөөс шалтгаалан тендер шалгаруулалт амжилтгүй болж хугацаа алдсан тохиолдол хэд хэд гарсан. Тухайлбал: Нийслэлийн 2017 онд зохион байгуулсан сургууль, цэцэрлэгийн барилгын ажлын тендер шалгаруулалт.
- Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тухай тайланг ихэнх төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлээгүй байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөөнд заасан хугацааны дагуу хэрэгжүүлэхгүй байх зөрчил нилээд байна.
- Худалдан авах ажиллагааны тайланг бараа, ажил, үйлчилгээний бүх эх үүсвэрээр бүрэн тайлагнахгүй байна.

1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт төсвийн эх үүсвэрт 2017 онд 327.5 тэрбум төгрөг төвлөрч, 322.2 тэрбум төгрөгийг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

Нийт эх үүсвэрийн 202.3 тэрбум төгрөг буюу 62.0 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 125.2 тэрбум төгрөг буюу 38.0 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна. Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 129.8 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 21.9 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 92.5 тэрбум төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 72.5 тэрбум төгрөг;

- УИХ-аас баталсан ЗГ хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 9.9 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Улсын төсөвт байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчаар нь авч үзвэл Батлан хамгаалахын сайдын зарлагын гүйцэтгэл 49.8 тэрбум төгрөг буюу нийт нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн 15.7 хувь, Эрчим хүчний сайд 30.8 тэрбум төгрөг буюу 9.7 хувь, Шадар сайдын гүйцэтгэл 26.4 тэрбум төгрөг буюу 8.3 хувь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын гүйцэтгэл 21.5 тэрбум төгрөг буюу 6.8 хувь, Эрүүл мэндийн сайдын гүйцэтгэл 20.5 буюу 6.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагын 26.4 хувь буюу 83.6 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 24.1 хувь буюу 76.3 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт, 14 хувь буюу 44.6 тэрбум төгрөгийг томилолтын зардалд, 5.8 хувь буюу 18.6 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 3.5 хувь буюу 11 тэрбум төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд зарцуулсан байна.

2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2017 онд 5,173.7 тэрбум төгрөгт хүрч, 109.4 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 446.4 тэрбум төгрөгөөр давсан, харин өмнөх оны гүйцэтгэлээс 1,279.2 тэрбум төгрөгөөр буюу 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны		2017	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,894,443.3	5,303,051.6	5,857,085.6	554,034.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0	242,417.9	325,680.2	83,262.4
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0	333,345.1	357,722.8	24,377.6
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,894,443.3	4,727,288.6	5,173,682.6	446,394.0
Татварын орлого	2,854,078.6	3,527,622.4	3,987,205.3	459,582.9
Орлогын албан татвар	519,958.7	728,674.7	962,144.9	233,470.2
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,140,721.4	1,448,504.9	1,618,492.1	169,987.2
Онцгой албан татвар	630,124.8	511,577.7	519,721.5	8,143.8
Тусгай зориулалтын орлого	10,767.4	11,941.1	12,386.6	445.5
Гадаад үйл ажиллагааны орлого	328,490.6	489,784.0	512,351.2	22,567.2
Бусад татвар, төлбөр, хураамж	224,015.6	337,140.0	362,109.0	24,969.0
Татварын бус орлого	1,040,364.8	1,199,666.2	1,186,477.3	-13,188.9
Нийтлэг татварын бус орлого	702,241.3	731,645.8	738,043.5	6,397.6
Хөрөнгийн орлого	253.8	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	247,188.5	272,381.6	253,019.0	-19,362.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	90,681.2	195,638.8	195,414.8	-224.0

Сая төгрөг

Улсын төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелсэн нь төсвийн тодотголоор төсвийн орлогын төлөвлөгөөг улс орны эдийн засгийн өнөөгийн байдалд нийцүүлэн тооцоолсноос гадна, төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 12. Улсын төсвийн зарим нэр төрлийн орлогын гүйцэтгэл, тайлбар

Орлогын өрөл	2016 гүйцэтгэл	2017 төлөвлөгөө	2017 гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
	1	2	3	3-2	
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,894.44	4,727.29	5,173.68	446.39	Тайлбар
Төлөвлөгөөнөөс давсан голлох орлогууд					
ААН-ын орлогын албан татвар	519.96	728.67	962.14	233.47	Аж ахуй нэгж орлогын албан татвар төлөвлөснөөс давж биелсэн нь уул уурхайн голлох эрдэс бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ өссөн, татвар төлөгч аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого_ашигт ажиллагааны түвшин нэмэгдсэнтэй шууд холбоотой байна.

Дотоодын барааны НӨАТ	558.33	600.70	734.28	133.58	Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (27.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.3 (26.1%) тэрбум америк доллар, импорт 977.3 (29.1%) өссөн нь дотоодын барааны НӨАТ төлөвлөснөөс давж биелэхэд нөлөөлжээ. Экспорт болон импортын хэмжээ өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум америк доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум америк доллар, эрдэс бүтээгдэхүүний импорт 261.6 сая америк доллар үүнээс дизелийн түлшний импорт 173.1 сая, автобензинийн импорт 51.1 сая ам доллараар нэмэгдсэнтэй холбоотой байна.
Импортын барааны НӨАТ	684.25	1,005.04	1,031.77	26.73	2017 онд 4375.4 сая ам дооларын бараа имдортлосон нь өнгөрсөн оны мөн үеэс 27.4 хувиар, төлөвлөснөөс 4.2 хувиар тус тус өсчээ. Импортын биет хэмжээ болон үнийн өсөлт төгрөгийн ханшны сулралаас хамаарч төгрөгийн үнийн дүнгийн импорт 10570.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 2.7 хувиар өсжээ. Энэхүү өсөлт нь импортын гаалийн албан татвар, Импортын НӨАТ-ын орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.
Импортын гаалийн албан татвар	328.35	489.78	512.35	22.57	2017 онд 4375.4 сая ам дооларын бараа имдортлосон нь өнгөрсөн оны мөн үеэс 27.4 хувиар, төлөвлөснөөс 4.2 хувиар тус тус өсчээ. Импортын биет хэмжээ болон үнийн өсөлт төгрөгийн ханшны сулралаас хамаарч төгрөгийн үнийн дүнгийн импорт 10570.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 2.7 хувиар өсжээ. Энэхүү өсөлт нь импортын гаалийн албан татвар, Импортын НӨАТ-ын орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.
Импортын тамхины онцгой албан татвар	78.15	74.49	93.28	18.78	Импортын тамхины онцгой албан татвар орлого 18.7 тэрбум төгрөгөөр даьж биелэсэн нь тамхины импортын тоо хэмжээ 5148.9 сая ширхэг буюу 23.4 хувиар өссөн, мөн импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой байна.
Төлөвлөгөөнөөс буурсан гол орлого					
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	320.75	155.84	124.60	-31.25	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь хэмжээнд 2017 онд нийт 3 удаа өөрчлөлт орж багасгасан нь төлөвлөгөөт орлого тасархад хүргэсэн байна.
Төсөвт байгууллагын өөрийн орлого	230.17	317.96	289.31	-28.65	Төсөвт байгууллагын өөрийн орлого 28.6 тэрбум төгрөгөөр тасарсан нь Хөдөлмөр нийгэм, хамгааллын сайд 10.0 тэрбум, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд 16.4 тэрбум төгрөгөөр тасарсантай холбоотой байна. ХНХЯ-ны төлөвлөгөөт орлого тасарсан нь гаднаас авах ажиллах хүчний тоог бууруулсантай холбоотой.
Хандив тусламж /гадаад/	76.34	74.49	56.33	-18.16	Гадаад тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна.

Тэрбум төгрөг

Төсвийн орлого дараах хүчин зүйлээс хамааран төлөвлөсөн хэмжээнээс өссөн байна.Үүнд:

- Уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний үнийн өсөлт болон түүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн
- Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 27.3 хувиар өссөн
- Өнгөрсөн оны татварын өр болох 1092.0 тэрбум төгрөгийн 77.6 хувь буюу 708.2 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан

2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2017 онд 7,139.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 281.0 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар бага гарсан байна. Харин өмнөх оны гүйцэтгэлээс 254.6 тэрбум төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Улсын төсвийн хүрээнд урсгал зардалд 5,524.2 тэрбум, хөрөнгийн зардалд 1,322.4 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 293.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 13. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны		2017	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,394,235.5	7,420,601.4	7,139,637.5	-280,963.9
НИЙТ ЗАРЛАГА	6,886,386.9	7,111,575.3	6,846,676.8	-264,898.5
УРСГАЛ ЗАРДАЛ	4,993,050.2	5,663,713.6	5,524,236.3	-139,477.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,951,062.5	2,001,758.9	1,901,793.0	-99,965.9
ХҮҮ	926,331.7	1,156,688.1	1,156,465.1	-223.0
ТАТААС	571,958.8	652,092.5	647,766.9	-4,325.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,543,697.2	1,853,174.0	1,818,211.3	-34,962.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,893,336.7	1,447,861.7	1,322,440.6	-125,421.1
Дотоод эх үүсвэрээр	1,893,336.7	1,447,861.7	1,322,440.6	-125,421.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	507,848.5	309,026.1	292,960.7	-16,065.4

Сая төгрөг

“Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 69, 29, 67 дугаар тогтоолуудыг баталж, уг тогтоолын дагуу төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг зорилтод бүлэгт чиглүүлж оновчтой байдлаар нэгтгэх, давхардлыг арилгах, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгох зэрэг арга хэмжээ авч ажилласан, мөн тогтоолоор 2018 оны төсвийн жил хүртэл “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байхаар заасныг хэрэгжүүлж ажиллаж байна.

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 570.2 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 146.2 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтэнд 1,066.1 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 53.0 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 373 төсөл арга хэмжээний 602,107.1 сая төгрөг, Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн 15 төсөл, арга хэмжээний 177,741.5 сая төгрөг, нийт 779,848.6 сая төгрөг батлагдсанаас санхүүжилтийн гүйцэтгэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 715,891.5 сая төгрөг буюу 91.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 14. Сүүлийн 5 жилийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

№	Он	Батлагдсан төсөв /тэрбум төгрөг/	Гүйцэтгэл /тэрбум төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
1	2013	1,174.3	789.1	67.2
2	2014	1,179.5	976.6	82.8
3	2015	357.9	246.9	69.0
4	2016	1,047.3	976.1	93.2
5	2017	779.8	715.8	91.8
Нийт дүн		4,538.7	3,704.5	80.8 <i>/5 жилийн дундаж/</i>

Үүнээс, 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 15. 2017 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

№	Төсвийн Ерөнхийлөн захирагч	Төсөвт өртөг /сая.төг/	2017 онд санхүүжих дүн /сая.төг/	Төсөл, арга хэмжээний тоо /шилжээг/	Гарсан санхүүжилт /сая.төг/	Үлдэгдэл /сая.төг/	Ашиглагдаагүй эх үүсвэрийн ангилал		Гүйцэтгэлийн хувь
							Тендерийн хэмнэлт /сая.төг/	Ажлын гүйцэтгэл гараагүй /сая.төг/	
1	Монгол Улсын Их Хурлын дарга	1,688.0	1,688.0	1	1,661.9	26.1	26.1	-	98.5
2	Монгол улсын ерөнхий сайд	362,528.0	180,519.8	16	178,736.2	1,783.6	1,783.56	-	99.0
3	Монгол улсын шадар сайд	45,243.4	7,055.1	10	6,985.7	69.4	14.3	55.1	99.0
4	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын дарга	17,253.7	5,763.3	6	4,508.0	1,255.3	11.8	1,243.5	78.2
5	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	2,593.5	824.3	3	714.2	110.1	70.0	40.1	86.6
6	Гадаад харилцааны сайд	5,978.2	1,518.2	2	1,518.2	0.0	-	-	100.0
7	Сангийн сайд	46,377.8	8,639.7	6	8,222.6	417.1	69.0	348.2	95.2
8	Хууль зүй, дотоод хэргийн сайд	74,833.1	33,337.3	9	33,306.3	31.0	31.0	-	99.9
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	25,720.7	7,810.8	11	7,464.7	346.1	12.4	333.7	95.6
10	Батлан хамгаалахын сайд	49,979.4	4,896.9	4	4,896.8	0.1	0.1	-	100.0

11	Барилга, хот байгуулалтын сайд	477,699.2	73,811.3	66	66,096.7	7,714.6	1,123.1	6,591.2	89.5
12	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	420,646.9	104,310.2	106	98,361.5	5,948.7	1,800.5	4,151.2	94.3
13	Зам, тээврийн хөгжлийн сайд	802,377.7	143,915.3	73	127,135.7	16,779.6	829.1	15,950.6	88.3
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	52,066.3	26,984.6	5	22,364.8	4,619.8	2,000.3	2,619.5	82.9
15	Эрүүл мэндийн сайд	194,679.1	61,740.8	29	60,823.8	917.1	387.3	529.8	98.5
16	Эрчим хүчний сайд	273,284.4	113,245.1	38	89,320.7	23,924.4	8,010.5	15,913.8	78.9
17	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	2,848.2	2,848.2	1	2,833.9	14.3	14.3	-	99.5
18	Улсын ерөнхий прокурор	952.7	88.3	1	88.3	0.0	-	-	100.0
19	Авлигатай тэмцэх газрын дарга	1,031.4	851.4	1	851.4	-	-	-	100.0
	Нийт дүн	2,857,781.7	779,848.6	388	715,891.5	63,957.1	16,183.2	47,776.7	

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд дараах барилга байгууламж ашиглалтад орсон. Үүнд:

- Сургуулийн барилга 22,
- Цэцэрлэг 34,
- Дотуур байр 4,
- Соёлын барилга байгууламж 7,
- Эмнэлгийн барилга, өргөтгөл 9,
- Төрийн үйлчилгээний конторын барилга 12,
- Хатуу хучилттай авто зам 518.5 км,
- Гүүрийн байгууламж 654.3 урт/метр,
- 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам 193.359 км,
- 110/35/10 кВ-ын 2*40 МВа хүчин чадал бүхий барилга байгууламж 8,
- Дулааны цахилгаан станцын шинэчлэл, дулааны шугам сүлжээ 5,
- Бага дунд оврын цэвэрлэх байгууламж 3,
- Махны үйлдвэр 1,
- Аврах гал унтраах ангийн барилга 5,
- Улсын хэмжээнд 18 аймагт 110 худаг зэргийг ашиглалтад оруулж, хүлээлгэн өгсөн байна.

Концессын эргэн төлөлт:

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессоор хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтаар нийт 15 төсөл, арга хэмжээнд 177,741.5 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс аудитын дүгнэлтэд үндэслэн 176,153.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Концессын гэрээний дагуу 2017 онд нийт авто зам 269.2 км, гүүрийн байгууламж 1,

Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-уул, Баянгол дүүргүүдэд нийт 4600 хүүхдийн хүчин чадал бүхий 4 сургууль, аймаг орон нутагт 720 хүүхдийн ор бүхий 7 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон.

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.3.1-д “Энэ хуулийн 6.1.2-т заасан эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх тусгай санд Засгийн газрын нөөц сан хамаарна” гэж заасны дагуу Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2017 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг тусгасан. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 16. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл

Үзүүлэлт	Дүн
2017 оны ЗГ-ын нөөц сангийн тодотгосон төлөвлөгөө	33,852,000,000.00
Засгийн газрын тогтоолын нийт дүн	30,033,923,923.00
Үүнээс: 2016 оны шийдвэрээр	2,058,620,600.00
2017 оны шийдвэрээр	27,975,303,323.00
Санхүүжүүлсэн нийт дүн	28,883,384,670.15
Санхүүжүүлээгүй дүн	4,968,615,329.85
Шийдвэрийн ілдэгдэл	3,818,076,077.00
Санхїжїллээгїй хїлээгдэж буй гїйцэтгэл	-

Төгрөгөөр

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны тодотгосон төлөвлөгөө 33,852.0 сая төгрөгөөр батлагдснаас 30,033.9 сая төгрөгийг зарцуулахаар Засгийн газрын шийдвэрїд гарсан байна.

Засгийн газрын шийдвэрїдийн дагуу нийт 28,883.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 85.3 хувийн гїйцэтгэлтэй гарсан байна.

3. ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сангийн тухай хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлан 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд тус санд 2017 онд 333,345.1 сая төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 357,722.8 сая төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 24,377.6 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар давж төвлөрсөн байна.

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил санг Ирээдүйн өв санд шилжүүлж байгаатай холбоотойгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг УИХ-аас баталсан. Уг хуулийн дагуу Сангийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож тооцсон Хүний хөгжил сангийн нийт 1,071,891.4 сая төгрөгийн өр улсын төсөвт шилжиж, Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэгдсэн.

2017 онд тус санд төвлөрсөн 357,722.8 сая төгрөгийн орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу 160,000.0 сая төгрөгийг улсын төсөвт шилжүүлж, 196,855.0 сая төгрөгийг Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт шилжүүлж, уг өрийн үлдэгдэл 875,036.4 сая төгрөг болсон.

4. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой баялгийн сан бөгөөд төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг. Уг санд 2011 оны 2 дугаар сараас хуримтлал бий болж эхэлсэн ба 2016 оны жилийн эцэст 332,023.84 сая төгрөгийн хуримтлал байсан ба 2017 онд тус санд эрдэс баялгийн орлогоос 242,417.9 сая төгрөг хуваарилагдахаар батлагдаж, гүйцэтгэл 325,680,2 сая төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 34.3 хувиар буюу 83,262.4 сая төгрөг илүү төвлөрсөн байна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 91.2.3-т Засгийн газрын нөөц сангийн болон Эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр нь Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэр байхаар заасны дагуу 5,311.3 сая төгрөгийг санд төвлөрүүлсэн. 2017 онд сангийн санхүүгийн хөрөнгөөс 478,000.0 сая төгрөгийг дотоодын 2 банкинд хугацаагүй хадгаламж хэлбэрээр,

хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан байдлаар байршуулж, 14,576.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 91.3.4, 34.2-т Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлалаас тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлж болохоор заасны дагуу 2017 онд 572,102.5 сая төгрөгийг зарцуулж, 2017 оны эцэст 104,168.9 сая төгрөгийн хуримтлалтай байна.

5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2017 онд 2,038.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 2,114.2 тэрбум төгрөг төвлөрч, 103.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 1,544.0 тэрбум төгрөг төвлөрч 105.2 хувийн биелэлттэй, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 570.2 тэрбум төгрөгт хүрч 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 17. НДС-ийн төсөв

Сая төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,038,195.2	2,114,238.1	76,042.9
Татварын орлого	1,467,962.8	1,544,005.7	76,042.9
Нийгмийн даатгалын орлого	1,467,962.8	1,544,005.7	76,042.9
Татварын бус орлого	570,232.4	570,232.4	0.0
Тусламжийн орлого	570,232.4	570,232.4	0.0
Хандив тусламж /дотоод/	570,232.4	570,232.4	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,907,540.6	1,890,850.6	-16,690.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,907,540.6	1,890,850.6	-16,690.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,431.8	20,142.3	-289.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,068.5	15,015.2	-53.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,664.1	1,657.9	-6.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,125.3	1,087.3	-38.0
Хангамж, бараа материалын зардал	430.7	427.2	-3.6
Эд хогшил, урсгал засварын зардал	66.0	65.6	-0.3
Томилолт, зочны зардал	128.8	126.9	-1.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,713.7	1,623.9	-89.9
Бараа үйлчилгээний бусад зардал	234.7	138.4	-96.3
ТАТААС	114,632.0	37,737.9	-76,894.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	114,632.0	37,737.9	-76,894.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,772,476.8	1,832,970.4	60,493.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	197,895.9	249,966.3	52,070.4
Засгийн газрын дотоод шилжүүлэг	197,895.9	249,966.3	52,070.4
Бусад урсгал шилжүүлэг	1,574,581.0	1,583,004.1	8,423.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,573,199.5	1,581,631.3	8,431.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	296.3	296.0	-0.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	627.3	627.3	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	457.8	449.5	-8.3
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	130,654.6	223,387.5	92,732.9
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-130,654.6	-223,387.5	-92,732.9
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-130,654.6	-223,387.5	-92,732.9

Харин нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 онд 1,890.9 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 99.1 хувьтай тэнцэж байна. Ингэснээр НДС нь 2017 онд 223.4 тэрбум төгрөгийн ашигтай байна.

6. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 2,437.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 2.6 хувь буюу 61.6 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Харин нийт зарлага 2,437.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 7.1 хувь буюу 186.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 18. Орон нутгийн төсөв

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,375,532.3	2,437,176.8	61,644.5
Татварын орлого	947,804.8	1,006,551.4	58,746.6
Орлогын албан татвар	626,158.8	651,047.9	24,889.1
Хөрөнгийн албан татвар	112,608.3	131,129.6	18,521.3
Бусад татвар, төлбөр, хураамж	209,037.6	224,373.8	15,336.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	87,841.9	87,435.9	-406.0
Газрын төлбөр	56,942.6	62,134.5	5,191.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	58,655.6	68,238.2	9,582.7
Бусад татвар	5,597.6	6,565.2	967.6
Татварын бус орлого	1,427,727.5	1,430,625.4	2,897.9
Нийтлэг татварын бус орлого	156,590.9	158,664.9	2,074.0
Хөрөнгийн орлого	1,197.1	1,187.9	-9.2
Тусламжийн орлого	2,091.2	5,507.6	3,416.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	1,267,848.3	1,265,265.0	-2,583.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,623,517.7	2,437,066.4	-186,451.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,121,641.1	2,078,310.7	-43,330.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,414,196.9	1,383,679.0	-30,517.8
ТАТААС	92,611.3	92,073.8	-537.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	614,833.0	602,557.8	-12,275.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	457,078.5	335,700.1	-121,378.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭ	44,798.1	23,055.5	-21,742.5
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-247,356.7	110.5	247,467.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	247,356.7	-110.5	-247,467.2
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр	194,972.8	-33,780.7	-228,753.4
ЗГ-ын зээл	47,303.8	28,520.0	-18,783.8
Гадаад	47,303.8	28,520.0	-18,783.8
Төслийн зээл	47,303.8	28,520.0	-18,783.8
Шинээр авах	47,303.8	28,520.0	-18,783.8
Өмч хувьчлал	5,080.1	5,150.2	70.1

Сая төгрөг

Орон нутгийн орлогын 41.3 хувь татварын орлогоос, 58.7 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 69.1 хувь буюу 695.1 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 44.5 тэрбум төгрөгийг олгосон байна. Бусад татвар, телбөр, хураамжийн орлогоор 224.4 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Татварын бус орлогын 88.4 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг /146.2 тэрбум/, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг /53.0 тэрбум/, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт /1,066.1 тэрбум/ -ийн орлогууд бүрдүүлж байна.

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 85.3 хувь буюу 2,078.3 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн зардалд 866.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 335.7 тэрбум төгрөгт хірч, төлөвлөсөн дүнгээс 121.4 тэрбум төгрөгөөр бага, өмнөх оны гүйцэтгэлээс 128.3 тэрбум төгрөгөөр бага байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 195.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

7. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,280.1 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 78.8 хувьтай тэнцэж байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 22,751.6 тэрбум төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг урьдчилсан ДНБ-д харьцуулсан харьцаа 74.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 19. Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн хэрэгслээр

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2016.12.31	2017.12.31
I. Засгийн газрын дотоод өр	6,464.9	4,230.1
1.1 Үнэт цаас	5,488.8	3,461.9
1.2 Өрийн бичиг/вексель	307.2	0.0
1.3 Концесс	668.9	768.2
II. Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8
2.1 Үнэт цаас	5,380.5	7,701.6
2.2 Зээл	6,983.3	9,156.2
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг	3,451.5	1,663.7
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.7
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	22,280.1	22,751.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	18,861.0	20,211.4
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0%	85.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	78.8%	74.4%

Тэрбум төгрөг


Засгийн газрын нийт өрийн багцын 18.6 хувийг дотоод өр, 74.1 хувийг Засгийн газрын гадаад зээл, үнэт цаас, 7.3 хувийг Засгийн газрын баталгаатай зээллэг эзэлж байна.

Засгийн газрын нийт дотоод өрийн 81.8 хувийг Засгийн газрын үнэт цаас бүрдүүлж байгаа бол 18.2 хувийг улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээний дагуу үүссэн төлбөрийн үүрэг тус тус эзэлж байна.

7.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2016 оны жилийн эцсээр 5,488.8 тэрбум төгрөг байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,461.9 тэрбум төгрөгт хүрч, 36.5 хувиар буураад байна.

График 0. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн мэдээлэл /тэрбум төгрөг/



Дотоод үнэт цаасны үлдэгдэл буурсан гол шалтгаан нь 2017 оны 11-12 дугаар сард арилжаалах хуваарьтай байсан 594.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг зогсоож, 2018-2023 онд төлөгдөх хуваарьтай байсан нийт 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсантай холбоотой.

Засгийн газрын дотоод үнэт цаасны хүүгийн хувь 2017 оны 1 дүгээр сард 17.7-18 хувьд хүрч хамгийн өндөр түвшиндээ хүрээд байсан бол 2017 оны 10 дугаар сарын байдлаар 11.6-13.95 хувьд хүрч, 4-6 хувиар буураад байна.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 80.9 хувийг улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 6.3 хувийг хүний

хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас эзэлж байна. Тусгай зориулалтаар гаргасан үнэт цаас болох 4000 айлын орон сууц хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 2011 онд арилжаалсан үнэт цаасны үлдэгдэл 1.9 тэрбум төгрөг, Сайн малчин болон Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны үлдэгдэл 375.7 тэрбум төгрөгийн үнэт цаас нь нийт дотоод үнэт цаасны үлдэгдлийн 10.9 хувийг эзэлж байна.

Засгийн газрын зүгээс 2017 онд улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлэх зорилгоор 3,376.6 тэрбум төгрөгийн үнэт цаасыг шинээр арилжаалсан. Үүнээс нийт арилжааны 80.0 хувь буюу 2,701.8 тэрбум төгрөгийн бөөний үнэт цаасыг Монголбанкны цахим системээр дамжуулан, 20.0 хувь буюу 674.8 тэрбум төгрөгийн жижиглэнгийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тус тус арилжаалж нийт 3,126.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг төрийн санд төвлөрүүлсэн. Арилжаалсан үнэт цаасыг хугацаагаар нь авч үзвэл 95.1 хувийг богино хугацаат буюу 1 жилээс бага хугацаатай үнэт цаас, 4.9 хувийг урт хугацаат буюу 2-3 жилийн хугацаат үнэт цаас эзэлж байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 5,124.6 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 562.5 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Үүнээс тусгай зориулалтын үнэт цаас буюу Сайн малчин, Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үнэт цаасны үндсэн төлбөрт 1,078.0 тэрбум төгрөг, улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 3,673.9 тэрбум төгрөг, Хүний хөгжил сангийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 372.7 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

7.2. ВЕКСЕЛЬ

Засгийн газрын зүгээс 2015-2016 оны хооронд нийт 400 гаруй аж ахуйн нэгжид 697.2 тэрбум төгрөгийн векселийг бичиж олгосноос 2016 онд 390.0 тэрбум төгрөгийн векселийн төлбөрийг эцсийн эзэмшигчид төлж барагдуулан, 2016 оны жилийн эцсээр векселийн үлдэгдэл 307.2 тэрбум төгрөг байсан.

Эдгээр векселийн төлбөрийг 2017 оны 5 дугаарын сарын байдлаар векселийн эцсийн эзэмшигчид болох Төрийн банк, Монгол Улсын Хөгжлийн банканд тус тус төлж барагдуулсан бөгөөд үндсэн төлбөрт 307.2 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 46.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Ингэснээр Засгийн газрын өрийн үлдэгдэлд векселийн өргүй болсон бөгөөд Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 47 дугаар тогтоолд аливаа хөрөнгө оруулалтын санхүүжилтийг векселиэр олгохгүй байхаар заасны дагуу шинээр вексель бичигдээгүй байна.

7.3. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчилсан бөгөөд хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас холбогдох журам, маягтад заасны дагуу улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2016 оны эцэст 668.9 тэрбум төгрөг байсан бол 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 768.2 тэрбум төгрөг байна.

Үүнээс, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй (барих-шилжүүлэх төрөл) нийт 29 концессын гэрээ байгуулж, эдгээр гэрээний хүрээнд гарсан ашиглалт, эргэн төлөлтийг оруулж тооцсоноор 750.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй нийт 18 гэрээний дагуу төлөх төлбөрийн үүрэг 17.3 тэрбум төгрөг байна.

7.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаас нь нийт өрийн багцын 33.9 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаад үнэт цаасны үлдэгдэл 2016 оны эцэст 2,161.2 сая ам.доллар буюу 5,380.5 тэрбум төгрөг байсан бол 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олон улсын зах зээлд нийт гаргасан Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл 3,173.1 сая ам.доллар буюу 7,701.6 тэрбум төгрөгт хүрээд байна.

Тайлант онд гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 950.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт нийт 408.5 тэрбум төгрөгийг тус тус төлөөд байна.

Хүснэгт 20. Засгийн газрын гадаад бондын 2017 оны үлдэгдэл

№	Гадаад бонд	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Дүн (сая USD)
1	Чингис-18	2012.12.05	4.125%	5	127.2
2	Чингис-22	2012.12.05	5.125%	10	1,000.0
3	Дим сам	2015.06.30	5.960%	3	145.9
4	Мазаалай	2016.04.06	10.875%	5	500.0
5	Хуралдай	2017.03.09	8.750%	7	600.0
6	Гэрэгэ	2017.11.01	5.625%	5.5	800.0
	НИЙТ				3,173.1

Засгийн газрын зүгээс Монгол Улсын Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын 82.07 хувийг Засгийн газрын 7 жилийн хугацаатай, 8.75 хувийн хүүтэй Хуралдай бондоор сольж, үлдэгдэл 124 сая ам.долларыг 7.625 хувийн зах зээлийн өгөөжтэйгөөр босгон хугацаанд нь амжилттай төлж дуусгасан.

Мөн 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 800 сая ам.долларын 5.5 жилийн хугацаатай, 5.625 хувийн хүүтэй Гэрэгэ бондоор 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх 500.0 сая ам.долларын Чингис бондын 74.5 хувь, 2018 оны 6 дугаар сард төлөгдөх 1.0 тэрбум юанийн Дим сам бондын 9.5 хувийг тус тус буцаан худалдан авсан бөгөөд бондын төлбөр тооцоо 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хийгдсэнээр Засгийн газрын өрд бүртгэгдсэн.

7.5. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж эдгээр олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж эхэлсэн ба 1991-2017 он хүртэлх хугацаанд нийт 4.5 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласан байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2017 оны эцэст 9,156.2 тэрбум төгрөг байгаа бөгөөд зээлийн нийт үлдэгдлийн 83 хувийг Азийн хөгжлийн банк, Япон, Бүгд Найрамдах Хятад ард улс, Дэлхийн банк гэсэн 4 том зээлдүүлэгчийн зээл эзэлж байна. Гадаад зээлийн үлдэгдэл 9,156.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 40.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 2,229.6 тэрбум төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрийг ашигласан /үүнээс төслийн зээл 751.5 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээл 1,478.1 тэрбум төгрөг/ ба гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 278.9 тэрбум төгрөг, үүнээс үндсэн төлбөрт 165.2 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 113.6 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

Томоохон зээлийн ашиглалтуудаас дурдвал Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн хүрээнд нийт 282.1 тэрбум төгрөг, Багуун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төслийн 2 дахь үе шат 50.7 тэрбум төгрөг байна.

7.6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын өрийн баталгааг Засгийн газар аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих, бага хүүгийн зардалтай хямд эх үүсвэрийг босгоход зориулан холбогдох хууль, журам, аргачлалын дагуу гаргаж байна.

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2016 оны эцэст 3,451.5 тэрбум төгрөг байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,663.7 тэрбум төгрөг байна. Баталгааны үлдэгдэл буурсан гол шалтгаан нь Засгийн газрын баталгаатай Монгол Улсын Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын төлбөрийг Засгийн газрын гаргасан Хуралдай бондоор сольж, үлдэгдэл 124 сая

ам.долларыг 7.625 хувийн зах зээлийн өгөөжтэйгөөр босгон хугацаанд нь амжилттай төлж дуусгасантай холбоотой.

Хүснэгт 21. Засгийн газрын өрийн баталгааны 2017 оны үлдэгдэл

#	Баталгааны дугаар	Зээлдүүлэгч	Валют	Зээллэгийн огноо	Баталгаа гаргуулагч	Зээлийн ангилал	Зээлийн дүн	2017.12.31	
								Үндсэн валютаар	Тэрбум MNT
I. ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА									
1	Хөгжлийн банк	Global Investors	USD	3/21/2012	Хөгжлийн банк	Үнэт цаас	580.0	-	-
2	МИАТ	PEFCO	USD	12/24/2013	МИАТ ХК	Зээл	77.5	103.9	42.8
3	МИАТ	ING Capital	USD	12/24/2013	МИАТ ХК	Зээл	24.0	22.8	10.3
4	МИАТ	ING Bank N.V.	USD	12/24/2013	МИАТ ХК	Зээл	20.0	48.5	20.0
5	Хөгжлийн банк	Japan Investors	JPY	1/6/2014	Хөгжлийн банк	Үнэт цаас	30,000.0	645.9	266.1
6	Хөгжлийн банк	China Development bank	USD	9/3/2014	Хөгжлийн банк	Зээл	162.0	327.7	135.0
7	Хөгжлийн банк	Credit Suisse	USD	9/5/2014	Хөгжлийн банк	Зээл	300.0	498.0	205.2
8	Эрдэнэс Монгол	Asian Development Bank	USD	4/1/2016	Эрдэнэс Монгол ХХК	Зээл	35.0	16.8	6.9
	НИЙТ							1,663.5	685.4
II. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС БАРЬЦААЛСАН									
1	Худалдаа хөгжлийн банк ⁴	Олон улсын хөрөнгө оруулагч	USD	5/19/2015	Худалдаа хөгжлийн банк	Үнэт цаас	500.0	1,213.6	500.0
	НИЙТ						500.0	1,213.6	500.0

Худалдаа хөгжлийн банк нь эзэмшиж байсан 993.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг барьцаалан баталгаа гаргуулсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.” гэж заасны дагуу 500.0 сая ам.долларын баталгааг Засгийн газрын баталгааны үлдэгдэлд оруулж тооцоогүй.

Өрийн удирдлагын тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсын Хөгжлийн банкны дунд хугацааны евробонд⁵, Самурай бонд, Кредит Свисс банкны зээл,

⁵Евробонд гэж тухайн улсын мөнгөн тэмдэгтээс өөр орны мөнгөн тэмдэгтээр бусад улсын нутаг дэвсгэрт бонд гаргахыг ойлгоно. Евробонд нь зөвхөн еврогоор гаргахыг ойлгохгүй бөгөөд анх Европын зах зээлд танилцуулагдсан учир Евробонд нэршилтэй болсон.

БНХАУ-ын Хөгжлийн банкны авсан зээл, МИАТ ТӨХК-ийн нисэх онгоц авах, Багануур ХК-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор авсан зээлд Засгийн газрын баталгаа гаргасан байна. Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаас хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бонд, Хөгжлийн банкны ОХУ-ын ВТБ банкнаас авсан зээл, Эрдэнэс Монгол ХХК-ийн Азийн хөгжлийн банкнаас авах зээл болон Алтны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор гаргасан баталгааг тус тус гаргасан байна.

--- о О о ---